

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02-р сарын 13-ны өдөр

№ 25/09

Улаанбаатар хот

Давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.21 дэх заалт, 13.7 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчид 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Нэгдүгээр хавсралтад заасан тооцооллын дагуу 2,040,000,000 (Хоёр тэрбум дөчин сая) төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн нэгж хувьцаанд олгох ногдол ашгийг 850 төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татварыг суутгаж “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Компанийн давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг давуу эрхийн хувьцаа эзэмшигчид хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

